



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 02 сарын 06 өдөр

Дугаар

1104

Жавхлант

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Ес зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г хавсралтаар баталсугай.
2. 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллахыг ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА



Р.ОЮУНЧИМЭГ

Засаг даргын Тамгын газрын даргын
2025 оны ᠒᠘-дугаар сарын ᠒᠖-ны өдрийн
᠒᠒᠘ дугаар тушаалын хавсралт

СДА0002

**ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хүрэх үр дүн	Хугацаа	Хариуцах албан хаагч
1	Ёс зүйн дэд хороо хагас жил тутамд хуралдах	Үйл ажиллагаа тогтмолжино	5, 11 сард	Т.Эрдэнэцэцэг
2	Ёс зүйн дэд хорооны хуралдааны тэмдэглэл хөтлөх	Хуралдаан бүр тэмдэглэлтэй байна	Тухай бүр	Э.Хонгорзул
3	Төрийн албанд анх удаа томилогдож буй албан хаагчдад ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ёс зүйн дүрэм, журам, хэм хэмжээний талаар сургалт зохион байгуулах	Төрийн албан хаагчийн ёс зүйн талаар мэдээлэл бэлтгэн сургалт зохион байгуулсан байна.	4, 10 сард	Г.Баасансүрэн
4	Байгууллагын бүх албан хаагчдад ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт зохион байгуулах	Сургалт зохион байгуулагдсан байна.	5 сард	Т.Эрдэнэцэцэг, Э.Хонгорзул
5	Албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн, ёс зүйн болон сахилгын зөрчлийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйн талаар гомдол, өргөдөл, мэдээлэл ирсэн тухайд шуурхай ажиллах	Мэдээлэл хүлээн авсан, олж мэдсэнээс хойш 14 хоногт багтаан холбогдох үйл ажиллагааг зохион байгуулсан байна	Тухай бүр	Ёс зүйн дэд хороо
6	Албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн эсэх асуудлыг хянан, эцэслэн дүгнэх	Зөвхөн нотлох баримтанд үндэслэн сахилгын шийтгэл ногдуулах эсэхийг шалган тогтооно	Тухай бүр	Ёс зүйн дэд хороо
7	Хариуцлага ногдуулахтай холбоотой Ёс зүйн дэд хорооны хуралдааны тэмдэглэл, дүгнэлтийг холбогдох материалын хамт байгууллагын	Дүгнэлт гарган танилцуулж, шийдвэрлүүлсэн байна	Тухай бүр	Т.Эрдэнэцэцэг

	даргад танилцуулж шийдвэрлүүлэх			
8	Албан хаагчийн ёс зүйн хэмжээ зөрчигдөж байгаа нийтлэг асуудлаар тухай бүр зөвлөмж гаргаж удирдах албан тушаалтанд хүргүүлэх	Удирдах албан тушаалтанд хүргүүлсэн байна.	Жилдээ	Ёс зүйн дэд хороо